



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2017 оны 02 сарын 08 өдөр

Дугаар Б/31

Хэрлэн сум

М.Болдыг Батширээт сумын
Засаг даргаар томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 26 дугаар зүйлийн 26.3, Улсын Их Хурлын 2007 оны "Улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" 73 дугаар тогтоолын 1, Засгийн газрын 2014 оны 333 дугаар тогтоолын "Зарим албан тушаалын цалингийн жишгийг шинэчлэн тогтоох тухай" 333 дугаар тогтоолын 1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын анхдугаар хуралдаанд оролцсон төлөөлөгчдийн олонхийн санал авсан, Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлгээ Авлигатай тэмцэх газарт хянуулж, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал тогтоогдоогүй, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.5, 26.5.1, 26.5.2, 26.5.3, 26.5.4, 26.5.5 дахь заалтад заасан шаардлагыг хангасан Магваны Болдыг 2017 оны 02 дугаар сарын 08-ны өдрөөс Батширээт сумын Засаг даргаар томилсугай.

Хоёр. Сумын Засаг дарга М.Болдын үндсэн цалинг 720257 /долоон зуун хорин мянга хоёр зуун тавин долоон/ төгрөгөөр, улс төрийн албан тушаалын албан ажлын онцгой нөхцөлийн нэмэгдлийг албан тушаалын цалингийн 30 хувиар тооцож цалинжуулахыг Батширээт сумын Засаг даргын Тамгын газрын нягтлан бодогчид зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА